



СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 02 сарын 21 өдөр

Дугаар А/67

Сүхбаатар сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 30 дугаар тогтоол, Монгол Улсын Шадар сайдын 2017 оны А/08 дугаар тушаал, Улсын онцгой комиссын 2020 оны 01/05 дугаар хуралдааны тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Шинэ коронавирусийн халдвараас урьдчилан сэргийлэх талаар Монгол Улсын Засгийн газар, Улсын онцгой комиссоос гарсан шийдвэрийн хэрэгжилтийг шуурхай зохион байгуулах мэргэжлийн байгууллагаас авч хэрэгжүүлж буй арга хэмжээг уялдуулан зохион байгуулах, нэгдсэн удирдлагаар хангах чиг үүрэг бүхий аймгийн Онцгой комиссын шуурхай ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хавсралт ёсоор баталсугай.


2.Шадар сайдын 2017 оны А/08 дугаар тушаалаар батлагдсан эрсдэлийн үнэлгээний аргачлалын дагуу аймаг, сумын түвшинд шинэ коронавирусийн халдварын эрсдэлийг үнэлэх, салбар тус бүр халдварын дэгдэлт үүссэн тохислдолд даван туулах чадавхийн үнэлгээг хийж тайланг аймгийн Онцгой комисст танилцуулж ажиллахыг Эрүүл мэндийн газрын дарга /Ж.Од/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ОРГИЛ

Сэлэнгэ аймгийн Засаг даргын
2020 оны 02 дугаар сарын 21-ны өдрийн
А/69 дугаар захирамжийн хавсралт



Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд:

Ажлын хэсгийн дарга:

Ж.Од

-Эрүүл мэндийн газрын дарга

Гишүүд:

Г.Баатар

-Онцгой байдлын газрын дарга, хурандаа

А.Энхбат

-Цагдаагийн газрын дарга, Цагдаагийн хурандаа

Ж.Отгонхүү

-Мэргэжлийн хяналтын газрын дарга

Ц.Эрдэнэчимэг

-Аймгийн Нэгдсэн эмнэлгийн дарга

Н.Эрдэнэбат

-Зооноз өвчин судлалын төвийн дарга

Ю.Ариунболд

-Хилийн мэргэжлийн хяналтын албаны дарга